

Анги, бүлэг .....

Шифр .....

**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН  
ДААЛГАВАР**

Хугацаа-60 минут

Нийт-20 оноо

**“А” ХУВИЛБАР**

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**ХАДАТ БУЛАГ**

Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ.

Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гаргаж сууснаа, дүрсгүй зан нь гэнэт хөдлөн худгийн ёроол руу жижигхэн чулуу унагавал “шол” гэснээ сураггүй болжээ. Том чулуу шидвэл ямар сүртэй дуу гарах бол гэж бодон хашлаганых нь чулууг арайхийн өнхрүүлж, худагт унагавал “пол” гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй.

Удсан ч үгүй худгийн ус ширгэж, хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл хатаж, мөчир нь нүцгэрэн, тэнгэрээс хур гүйн сарвайв. /Н.Өлзийбат/

1. Дараах үгс эхэд ямар утгаар орсон бэ? тайлбарлаарай. **/2 оноо /**

Худаг лайдах- .....

Нүцгэрэх - .....

Саглагар - .....

Хавийн- .....

2. “Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гаргав”. гэсэн өгүүлбэрээс 3 бүрэлдэхүүнт цөм бүтцийг ялгаж бичээрэй. **/2 оноо /**

3. “Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ.” өгүүлбэрээс тийн ялгалын нөхцөлтэй үгсийг ялган бичээд бүтээврээр задлаарай. **/2 оноо /**

4. Эхийг бүтцээр зааглаарай. **/2 оноо /**

Эхлэл хэсэг.....

Гол хэсэг.....

Төгсгөл хэсэг .....

5. “мэдэхэд” гэдэг үгэнд холбогдох зөв бичих дүрмийг тайлбарлаарай. **/2 оноо /**

6. Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгт шаргачныг хөнөөсөн хүмүүст ямар хариуцлага хүлээлгэх вэ? Өөрийн үзэл бодлоор тайлбарлан бичээрэй. Ийм үйлдэл хийж болох уу?  
**/5 оноо /** үгийн тоо 30-40.

7. Дараах эхийг уншаад, кирилл бичигт хөрвүүлэн бичнэ үү? /5 оноо/

БАЯН-УУЛ ЕБС  
БАЯН-УУЛ ЕБС  
БАЯН-УУЛ ЕБС  
БАЯН-УУЛ ЕБС  
БАЯН-УУЛ ЕБС  
БАЯН-УУЛ ЕБС

.....

.....

.....

.....

.....

Анги, бүлэг .....

Шифр .....

**6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа:60 минут

Нийт:20 оноо

**“Б” ХУВИЛБАР**

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**МОДОН ТОРХТОЙ БАЛ**

Баавгай модон торх хийж зөгийн үүрний дэргэд тавив.

Алаг зөгийнүүд эрээн цэцгийн дэлбээн дээр өдөржин бэлчээрлэж, оройхон үүрэндээ ирнэ. Үүрэн сархинагтаа амтат бал боловсруулж үүрнээсээ зөөж торхонд хийнэ. Баавгай ойгоор тэнэж торхны мод аваад ирэхэд л амтат бал торхонд байдаг байжээ. Баавгай амтат балаа идсээр зун намрыг өнгөрөөж аглаг хөвч цасанд дарагдав. Баавгай ичээндээ оров.

Баавгай хэнз яргуйтай уралдан ичээнээсээ гарч аглаг ой, аглаг цэцэгт ургамал, амтат балын эзэн эрээн зөгийнүүдээ эрээд эрээд олсонгүй. Дээрэнгүй эздийн огтолсон ойн хожуул ёрдойно. Баавгай дэргэд нь нулимыс дуслуулан зогсоно.

Уншиж ойлгох чадварыг сорих даалгавар

1. Дараах үгс эхэд ямар утгаар орсон бэ? тайлбарлаарай. /2 оноо /

Бэлчээрлэх- .....

ёрдойх -.....

сархинааг -.....

дээрэнгүй - .....

2. “Баавгай амтат балаа идсээр зун намрыг өнгөрөөв”. гэсэн өгүүлбэрээс 3 бүрэлдэхүүнт цөм бүтцийг ялгаж бичээрэй. /2 оноо /

.....

3. “Алаг зөгийнүүд эрээн цэцгийн дэлбээг өдөржин манаж аглаг ойгоор хэсүүчлэн амтат балыг цуглуулан модон торхонд хийв.” өгүүлбэрээс тийн ялгалын нөхцөлтэй үгсийг яланг бичээд бүтээврээр задлаарай. /2 оноо /

.....

.....

4. Эхийг бүтцээр нь зааглаарай. /2 оноо /

Эхлэл хэсэг - .....

.....

Гол хэсэг - .....

.....

Төгсгөл хэсэг - .....

5. “**бодоход**” гэдэг үгэнд холбогдох зөв бичих дүрмийг тайлбарлаарай. /2 оноо /

.....

.....

6. Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгт шаргачныг хөнөөсөн хүмүүст ямар хариуцлага хүлээлгэх вэ? Өөрийн үзэл бодлоор тайлбарлан бичээрэй. Ийм үйлдэл хийж болох уу?  
/5 оноо / үгийн тоо 30-40.

.....

.....

.....

.....

7. Дараах эхийг уншаад кирилл бичигт хөрвүүлэн бичнэ үү. /5 оноо /

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....